

ДЭЛҮҮН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН

АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГАА ХАНГАХ

АЖЛЫН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024.12.10

Дэлүүн сум

Д/д	Арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	Төрийн албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө олгох цалин хөлсийг цаг хугацаанд нь хуулийн дагуу олгох, ажлын үр дүнг үнэлэн урамшуулах, тэмдэглэлт баяр ёслолын өдрүүдийг тохиолдуулан шагнах.	Сумын хэмжээнд 78.0 сая	Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 276 дугаар, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, 2022 оны Тогтоол, тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 192 дугаар тогтоол, Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 194 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2022	100%

			<p>оны 120 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган төрийн албан албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэн ажлын үр дүнг харгалзан олгосон. Засгийн Газрын 2022 оны 194 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд Туслах түшмэлээс Дэс түшмэлийн ангилалд, Санхүүгийн албаны даргыг ТЗ-7 зэрэглэл, Ахлах түшмэлийн ангилалд тус тус шилжүүлсэн ба дээрх тогтоолуудын дагуу Төрийн захиргааны албан хаагчийн цалингийн нэмэгдлийг олгов. Тус сумд үйл ажиллагаа явуулдаг 11 төрийн байгууллага, Эрэн хайх, аврах бүлэг, Цагдаагийн хэсэгт нийт 478 төрийн албан хаагч ажилдаг. Төрийн албан хаагчдын албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө олгох цалин хөлсийг цаг хугацаанд сард хоёр хувааж олгож байна. 2024 оны төсвийн жилд нийт төсөвт байгууллагууд цалин хөлсөө бүрэн олгож, үр дүнгийн урамшууллыг зохих хууль журмын хүрээнд олгосон болно. Төсөвт байгууллагууд жилийн эцэст ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж үнэлгээ өгч ажиллаг байна. ЗДТГазарт ажилладаг албан хаагчид жилийн эцэст амжилт гаргасан албан хаагчдад 8.9 сая төгрөгийн урамшуулал олгосон ба 2024 онд амжилт гаргаж ажилласан татварын байцаагч, 10 дугаар багийн засаг дарга, Хөдөө аж ахуйн тасгийн хоёр мэргэжилтнийг шагнасан болно. Төсвийн жилд ИТХурал 242.0 мянган төгрөг, Соёлын төв 6.5</p>	
--	--	--	---	--

			<p>сая төгрөг, Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 8.2 сая, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 9.0 сая, Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль 150.6 сая, Хүүхдийн нэгдүгээр цэцэрлэг 14.3 сая, Хүүхдийн хоёрдугаар цэцэрлэг 22.4 сая, Хүүхдийн гуравдугаар цэцэрлэг 31.4 сая, Эрүүл мэндийн төв 31.8 сая нийтдээ 283.1 сая төгрөгийн урамшууллыг 478 албан хаагчдад олгосон. Боловсролын салбарт амжилт гаргасан 3 багшийг шагнаж урамшуулсан. Эрүүл мэндийн салбарт амжилт гаргаж ажилласан хоёр сувилагчийг шагнаж урамшуулах асуудлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэсэн. Салбар бүрийн олон жил үр бүтээлтэй амжилт гарган ажилласан ахмад албан хаагчдыг төрийн одон медалиар шагнах асуудлыг хууль журмын хүрээнд шийдвэрлүүлэн ажиллаж байна.</p>	
2	ЗДТГ-ын албан хаагчдын мэдлэг чадвар, мэргэжил боловсролыг дээшлүүлэх сургалтыг тусгай хөтөлбөр боловсруулан сумын Засаг даргаар батлуулан мөрдөж ажиллах	1.2 сая	<p>ЗДТГ-ын албан хаагчдын мэдлэг чадвар, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газрын харьяа Төрийн албаны сургуульд хүсэлт гаргаж дөрвөн албан хаагчдыг сургалтад хамруулан ажиллав. ЗДТГазрын дарга ахлах түшмэлийн сургалтад, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Хүнс, ЖДҮйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн нар дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан болно. Төрийн захиргааны хоёр албан</p>	100%

			хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулахаар материалаа хүргүүлэн ажиллаж байна. Төрийн захиргааны албан хаагчдыг аймаг болон УБ хотод зохион байгуулагдсан сургалт семинарт хамруулж замын зардал, томилолтын зардлыг бүрэн шийдвэрлэн өгч ажилласан.	
3	Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх	Амралтын цалинг хууль журмын хүрээнд бүрэн олгосон.	Монгол Улсын хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх ажлыг сумын төсвийн шууд захирагч нарт үүрэг даалгавар өгч хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах мөн 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл бүх ажилтан албан хаагчдын ээлжийн амралтыг эдлүүлэх ажлыг зохион байгуулсан. 2024 оны орон нутгийн сонгууль 10 дугаар сард товлогдсон тул ажилтан албан хаагчдын амралтын хуваарь, ээлжийн амралтын цалингийн тооцоог 9 дүгээр сарын сүүлээр дуусгавар болгон ажилласан.	100%
4	Өөрийн хүсэлтээр мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, давтан сургах, аминдаа орон сууц барих, бусад амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлсээ худалдан авахад зориулж	49 сая	Тус сумын хэмжээнд төрийн байгууллагуудад ажилдаг ажилтан албан хаагчдын судалгааг гаргаж хяналт тавин ажиллаж байна. Нийгмийн эмзэг бүлэг, өрх толгойлсон, өвчтэй ямар нэгэн эрсдэлд өртөх болзошгүй төрийн албан хаагчидтай уялдаа холбоотой санхүүгийн болон сэтгэлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2024 онд сумын хэмжээнд гадаад улсад эмчилгээнд явж ирсэн нэг албан	100%

	зээлийн баталгаа гаргаж өгөх.		хаагчдад 3.0 сая төгрөг, эмзэг бүлгийн зургаан албан хаагчдад тус бүр 1тн нүүрсний дэмжлэг үзүүлсэн байна. Эмзэг бүлгийн тоонд ордог тэтгэвэрт гарсан 2 ахмад настнуудын оронд нь гэр бүлийн гишүүдийг ажилд оруулах талаар төсвийн шууд захирагч нарт зөвлөсний дагуу эмзэг бүлгийн 2 хүнийг байнгын ажлын байртай болгосон. 2024 онд аминдаа орон сууц барихад санхүүгийн хэрэгцээ гарсан албан хаагчид гэрээний дагуу сумын төвд үйл ажиллагаа явуулдаг Төрийн банк, Хаан банкнаас цалингийн зээл авч нэн чухал хэрэгцээг ханган ажилласан.	
5	Ажлын холбогдолтой сургалт, семинарт гадагшаа явах унааны болон томилолтын зардал олгох.	43.5 сая	Төрийн албан хаагч нарт чиглэсэн гадаад, дотоодын сургалт семинарт албан хаагч нараа бүрэн хамруулан ажиллаж байна. Монгол улсын Засгийн газраас санаачлан зохион явуулсан АЛСЫН ХАРАА-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Шинэ сэргэлтийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, “Бүсчилсэн хөгжил Эдийн засгийн форум” үндэсний хэлэлцүүлэг, “Шинэ хоршоо хөдөлгөөн” сургалтад Засаг дарга, ЗДТГазрын дарга, 12 багийн засаг дарга нар бүрэн хамрагдсан. Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх сургалтад ХАА тасгийн мэргэжилтэн, малчин, хоршоологчид оролцоход зохих хэмжээний дэмжлэг үзүүлсэн. Мөн төсвийн шууд захирагч нар салбар салбарын албан хаагчид сургалтад тогтмол хамрагдаж сургалтад хамрагдахад замын	90%

			зардал, томилолтын мөнгийг төсвөөс хууль журмын хүрээнд бүрэн олгосон. Тус сумын хэмжээнд 2024 онд 92 албан хаагчдад 19.8 сая төгрөгийн томилолтын зардал олгосон. Албан үүргээ гүйцэтгэхэд хувийн унааг ашигласан 91 албан хаагчдад 23.7 сая төгрөгийн шатахууны зардал олгогдсон.	
6	Албан үүргээ биелүүлэхтэй нь доромжлох, гүтгэх, бусад хууль зөрчсөн үйлдлээс ажилтан ажиллагчдыг болон гэр бүлийг хамгаалах.		Албан үүргээ биелүүлэхтэй нь доромжлох, гүтгэх, бусад хууль зөрчсөн үйлдлээс ажилтан ажиллагчдыг болон гэр бүлийг хамгаалах ажлыг маш сайн зохион байгуулан ажиллаж байна. Ард иргэдэд хууль тогтоомжуудыг сурталчлах, ажилтан албан хаагч нарт чиглэсэн хууль журмын талаар мэдлэгийг дээшлүүлэх талаар 2024 онд нийт давхардсан тоогоор 48 удаа сургалт зохион байгуулж ажиллав. Албан үүргээ биелүүлж байгаа төрийн албан хаагч нарт зүй бус харьцах, доромжлох асуудал гараагүй болно. Багуудын БИНХурлыг жилд хоёр удаа зохион байгуулах үеэр ЗДТГазрын төрийн захиргааны албан хаагчид болон боловсрол, эрүүл мэндийн салбарын удирдлагууд болон холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулж иргэдэд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулдаг болсон.	100%

7	Сумын ИТХ болон Засаг дарга /Улс төрийн албан хаагч/-ийн албан тушаалаас өөрчлөгдөх нь ЗДТГ-ын ажилтан ажиллагчдыг ажлаас өөрчлөх үндэслэл болохгүй байх		Орон нутгийн сонгуулийн жил болсонтой холбоотой улс төрийн 2 албан хаагч шинээр ажилд орсон ба бусад байгууллагын хувьд ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтан албан хаагч байхгүй. ЗДТГазард ажилдаг төрийн захиргааны гурван албан хаагчийн ёс зүйн асуудлыг авч хэлэлцэж хууль журмын хүрээнд хариуцлага тооцох асуудлыг авч хэлэлцсэн.	90%
8	Өөрийн хүсэлтээр буюу албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлснээс бусад тохиолдолд ажлаас халах, чөлөөлөхгүй байх, ажлын байрыг хэвээр хадгалагдах хуулийн заалтууд болон байгууллагын дотоод журмыг мөрдөх.		Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой бүх төсөвт байгууллагууд хөдөлмөрийн дотоод журмаа шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллаж байна.	90%
9	Ажилтан ажиллагчид гашигдал өвчин зовлон тохиолдолд хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу тэтгэмж тусламж олгох.	6.4 сая	Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтан ажиллагчид гачигдал өвчин зовлон тохиолдсон бол байгууллагаас зохих хэмжээний дэмжлэг үзүүлэх заалтыг оруулж мөрдөж ажиллаж байна. ЗДТГазрын нягтлан бодогч хагалгаанд орж ирэхэд 3.0 сая төгрөгийн тусламж олгосон. Төрийн байгууллагууд өөр өөрсдийн төсвийн бололцоогоор болон хамт олноос хандив цуглуулж эмзэг	90%

			бүлгийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.	
10	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгслээр хангах,	190.0 сая	Төрийн албан хаагчид төрийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардлыг төсвөөс сар бүр олгож ажилласан. ЗДТГазар 28.0 сая төгрөг, ЭМТ 12.0 сая төгрөг, Боловсролын салбар 150.0 сая төгрөг нийт 190.0 сая төгрөгөөр компьютер, принтер, сканер худалдаж авч 66 албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажилсан. Бичиг хэргийн зардлыг төсвөөс сар бүр хяналттай олгож байна.	90%
11	Албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар хангах,	24.0 сая	Төрийн албан хаагчдыг албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар ханган ажилладаг. 2023 онд 10 багийн засаг дарга, 10 хүний бага эмч нарыг унаажуулах асуудлыг бүрэн шийдвэрлүүлсэн. 2024 онд намар тарваган тахлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвөл,хавар их хэмжээгээр цас орж малчдын байдал хүндэрсэн үед, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд төрийн албан хаагчдыг унаагаар ханган ажилласан. ЗДТГазарт туулах чадвар муу дунд гарын машин байгаа ба заримдаа хувийн унаагаар болон ЭМТөвийн фургон машин, Хөх сэрх ДЦГ-н ланд-79 машинуудыг дайчлан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. 2024 онд өвөлжилт маш хүнд болж багуудын зам даваа хаагдахад мэргэжлийн ангийн бие	100%

			бүрэлдэхүүнүүд үүрэг гүйцэтгэхэд албаны болон иргэдийн унааг дайчлан ажилласан. Төрийн ажлыг гүйцэтгэхэд иргэдийн унааг ашиглахад шатахууны болон томилолтын зардал олгоход 24.0 сая төгрөгийн зардал гарсан байна.	
12	Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөр шийдвэрүүлэх.		Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/384 дүгээр захирамжийн дагуу ХАА-н тасгийн мэргэжилтэн ЖДҮХХ мэргэжилтэн болон БОХУлсын байцаагчид дэс түшмэлийн дэд зэрэг ахиулан олгогдож 18%-ийн нэмэгдэл, 2023 оны аймгийн засаг даргын захирамжаар Хууль эрх зүйн мэргэжилтэн, Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мал зүйч нарт ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэж зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлүүлсэн.	100%
13	Албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшууллын асуудлыг шийдвэрлэх,		Тус сумын ЗДТГазрын төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэсэн. Нийт 6 төрийн захиргааны албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон.	90%
14	Албан хаагчдын ажилласан жилийг харгалзан төрийн алба		Албан хаагчдын ажилласан жилийг харгалзан төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг журмын дагуу олгох асуудлыг бүрэн	90%

	хаасан хугацааны нэмэгдлийг журмын дагуу тухай бүр нь шийдвэрлэх,		шийдвэрлэн цалин хөлсийг олгож байна.	
15	Гачигдалтай болон тэмдэглэлт үйл явдал, арга хэмжээний үед олгох буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг тогтоон олгож байх,		Гачигдалтай болон тэмдэглэлт үйл явдал, арга хэмжээний үед олгох буцалтгүй мөнгөн тусламжийн хэмжээг байгууллага бүр хөдөлмөрийн дотоод журмаараа шийдвэрлэж байна.	90%
16	Албан хаагчдыг жилдээ нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд хамруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;		Монгол улсын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, эмнэлгийн оношилгоонд сумын нийт төрийн албан хаагчдыг хамруулах талаар ажил зохион байгуулсан. ажилтан албан хаагчдыг аймагт явж ирэх замын зардлыг байгууллагаас шийдвэрлэн өгч ажилласан.	100%
17	Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт нь албан тушаалын 3 жилийн цалинг, биед нь гэмтэл учруулсан тохиолдолд эмчилгээний	60 сая төгрөг	2023 онд ИТХурлын нарийн бичгийн дарга албан үүргээ гүйцэтгэж байхад нас барсан тохиолдол гарсан. Холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлж аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст уламжилж түүний ар гэрт 60.0 сая төгрөг олгохоор шийдвэр гарч тэтгэмжийг 2024 онд олгосон байгаа.	100%

	зардлыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгох,			
18	Байгууллага, хамт олны дунд найрсаг, бие биенээ хүндэтгэсэн орчин албан хаагчдын зөв харилцаа, хандлага, соёлыг төлөвшүүлэх, сайн туршлагыг дэмжих дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;		Байгууллага, хамт олны дунд найрсаг, бие биеэ хүндэтгэсэн орчин албан хаагчдын зөв харилцаа, хандлага, соёлыг төлөвшүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ЗДТГазрын хамт олны зүгээс Ховд аймгийн Дуут сумын ЗДТГазар, Завхан аймгийн Ургамал сумын ЗДТГазрын хамт олонтой туршлага судлах, харилцан зөвлөлдөн ажиллах талаар уулзалт зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 1,2,3 дугаар сургуулийн багш нар Булган сумын Ерөнхий боловсролын нэг дүгээр сургууль, Толбо сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуульд туршлага судлах чиглэлээр хамтран ажилласан. Хүүхдийн 1,2-р цэцэрлэгийн хамт олон аймаг болон Толбо сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж сайн туршлагаасаа хуваалцаж ажилласан.	100%
19	Төрийн албан хаагчдад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох;		Эрүүл мэндийн төвийн эмч нар БИНХурлын үеэр ард иргэдэд байнга мэдээлэл хүргэж ажилдаг. Мөн төрийн албан хаагч сурагч нарт чиглэсэн сургалт семинар явуулж эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар санаачилгаатай ажиллаж байна.	100%
20	Төрийн албан хаагчдыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж		Байгууллага бүр хөдөлмөрийн дотоод журмын дагуу УБ хотод оношилго хийлгэхэд 8 хоног, Бүсийн эмчилгээ оношилгооны төвд үзүүлж эмчилгээ хийлгэсэн албан хаагчдад ажлын 5 хоног цалинтай	100%

	шаардлагатай хүмүүст эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад нь дэмжлэг үзүүлэх;		чөлөө олгож байна. Аймгийн эрүүл мэндийн газраас гаргасан хуваарийн дагуу сумын нийт албан хаагчдаа жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж ажилласан.	
21	Тухайн албан хаагчийн сарын цалингаас илүү төлбөртэй эмчилгээг зайлшгүй хийлгэх болсон тохиолдолд эмнэлгийн тодорхойлолт, эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг харгалзан тухайн ажилтны эмчилгээний зардалд нь албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй мөнгөн тусламж олгож, дэмжлэг үзүүлэх;	3.0 сая	2024 онд Гадаад улсад хагалгаанд орж ирсэн ЗДТГазрын нягтлан бодогч А.Айсаулед орон нутгийн орлогын давсан хэсгээс 3.0 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Нийгмийн эмзэг бүлэгт тооцогддог зарим албан хаагчдад байгууллага бүр зохих хэмжээний дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	100%
22	Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилдээ хоёроос доошгүй удаа идэвхтэй амралт зохион байгуулах;		Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж чиглэлээр хавар 5 дугаар сард боловсролын салбарын нийт ажилтан албан хаагчид цэвэр агаарт гэр бүлээрээ явган аялал зохион байгуулсан. ЗДТГазрын ажилтан албан хаагчид 6,9 дүгээр сард хоёр удаа цэвэр агаарт аялсан. Эрүүл мэндийн төв, Хүүхдийн 1,2,3	100%

			дугаар цэцэрлэгийн хамт олон Толбо сумын амралтын газарт аялж ирсэн.	
23	Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор долоо хоногт нэг удаа спорт зааланд чөлөөлт тоглолт явуулах;	5.0 сая	Сумын хэмжээнд биеийн тамир спортын тэмцээний арга хэмжээг 3 удаа зохион байгуулсан байгаа. Тэмцээнд төрийн албан хаагчдыг татан оролцуулан ажилласан. Мөн аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан багш нарын спортын их наадамд волейболын төрлөөр тус сумын багш нарын баг тамирчид амжилттай оролцсон. Сумуудын ЗДТГ, ИТХурлын ажилтан нарын дунд зохион байгуулагдсан тэмцээнд багаа маш сайн бүрдүүлэн оролцуулсан. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн салбарын дунд зохион байгуулдаг спортын тэмцээнд Эрүүл мэндийн төвийн баг тамирчид амжилттай оролцож сүүлийн 4 жил дараалан тэргүүн байр эзэлж байв. Төсвийн шууд захирагч нартай хамтран сард 3-4 удаа төрийн албан хаагчдыг зааланд тоглуулж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх талаас нь санаачилгаатай ажил зохион байгуулсан.. 2024 онд сургуулийн спорт заалны засварын ажлыг төрийн албан хаагчид хүн бүрээс 10.0 мянган төгрөг цуглуулж нийт 2.4 сая төгрөгөөр засварлаж авсан. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилан өгч спорт заалны цонхыг бүрэн вакум цонхтой болгосон.	100%

24	Ажилтан, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах, бусад аймаг, сумуудтай хамтран ажиллаж туршлага судлах;	69.9 сая	<p>Ажилтан албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах чиглэлээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт 7.5 сая төгрөг, Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгт 5.0 сая төгрөг, Соёлын төвд 10.0 сая төгрөг, ЗДТГазард 16.4 сая төгрөг, Хөх сэрх тусгай хамгаалалтын захиргаанд 5.0 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж тоног төхөөрөмж, өрөөний тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4 ширээний компьютер, 2 өнгөт принтер хуваарилуулан авч ЗДТГазрын албан хаагч нарт олгосон. Мөн байгаль хамгаалагч 3 албан хаагчдад зөөврийн 3 ш компьютер, 1ш өнгөт принтер тус бүрд нь 3 мотоцикл олгосон байгаа. Нийт 21 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>Сумд ажиллаж байгаа Олон нийтийн хоёр цагдааг хувцсаар хангахад 2.0 сая төгрөг унаажуулахад 3.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлсэн.</p> <p>Төрийн бүтээмжийг дээшлүүлэхэд зорилт тавьж сумын хэмжээнд хэд хэдэн ажил зохион байгуулсан болно. Үүнд ажилтан албан хаагчдын цаг ашиглалт зөв хувцаслах, бусад аймаг сумдын төрийн байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр Завхан аймгийн Ургамал сум, Ховд аймгийн Дуут сум, Говь Алтай аймгийн Жаргалант сумуудын ИТХ, ЗДТГазрын хамт олонтой уулзалт</p>	100%
----	--	----------	--	------

			зохион байгуулж өөр өөрсдийн ажлаа танилцуулан хамтран ажиллаж туршлага солилцсон. Сумуудтай репийн холбоо тогтоож хамтран ажиллаж байна.	
25	Сумын нийт албан хаагчдын дунд соёл урлагийн ажлыг зохион байгуулах;	1.0 сая	Сумын засаг даргын зөвлөлийн шийдвэрээр сумын нийт төрийн албан хаагчдын дунд урлагийн тоглолт зохион байгуулсан. Урлагийн тоглолтод 9 төрийн байгууллагаас 13 баг өрсөлдөж Соёлын төвөөс 1.0 сая, ЗДТГазраас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж багуудыг шагнан урамшуулах асуудлыг шийдвэрлэсэн. Мөн төрийн албан хаагчдын урлагийн тоглолтыг хөрш зэргэлдээ сумуудаар очиж тоглож соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байгаа.	100%
	<b>Ерөнхий дүн</b>			96.8

**БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН**

**К.САНДГҮЛ**

**ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА**

**С.АМАНКЕЛД**